



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 1/207

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох, нэр шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Адарга сумын "Ариун дуурлиг" ХХК-ий хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

- | | |
|---------------------|---------------------------|
| 1. Баянмөнх сум | "Энхмагнай-2" ХХК |
| 2. Цэнхэрмандал сум | "Мөнх мандал хайрхан" ХХК |
| 3. Жаргалтхаан сум | "Арвижих бэт" ХХК |
| 4. Норовлин сум | "Хаан тариа" ХХК |
| 5. Хэрлэн сум | "Бавуу тамир" ХХК |
| 6. Бэрх тосгон | "Арвижих-Ану тоонот" ХХК |
| 7. Хэрлэн сум | "Шинэ эс" ХХК |
| 8. Дэлгэрхаан сум | "Мэргэн дал" ХХК |
| 9. Батширээт сум | "Жаргалбилэг" ХХК |

Баар:

- | | |
|------------------|-------------------------|
| 10. Баянмөнх сум | "Энхмагнай" ХХК |
| 11. Бэрх тосгон | "Наран хаан бүргэд" ХХК |
| 12. Батноров сум | "Өнөр-Үүд" ХХК |

011015

2//.

13. Хэрлэн сум "Нямодо трейд" ХХК
14. Бор-Өндөр сум "Тэнгэрт мөргөмүй" ХХК

3. Дараах аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсүгэй.

Хүнсний дэлгүүр:

15. Хэрлэн сум "Их ханан" ХХК
Баар:
16. Дадал сум "Мустанг хүлэг" ХХК

4. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

Хүнсний дэлгүүр:

17. Баян-Адарга сум "Дэвшил-Онон" ХХК
18. Баян-Адарга сум "Мөнхийн дуурлиг" ХХК
19. Биндэр сум "Энх мөнхийн үүд" ХХК
Баар:
20. Цэнхэрмандал сум "Баян сэрүүч" ХХК
21. Биндэр сум "Энх мөнхийн үүд" ХХК
22. Хэрлэн сум "Бүс чандмань" ХХК

5. Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Умардын-Од" ХХК нь татан буугдаж "Өндөрхаан сүлд" ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байгаа тул согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийн нэрийг "Өндөрхаан сүлд" ХХК болгон өөрчилсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комисс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Н. ГАНБЯМБА